

**ХҮН, ХҮЛЭГ ХОЁР ХЭМЭЭХ ТАНИН МЭДЭХҮЙН
УТГА ЗҮЙН ЗЭРЭГЦҮҮЛЭЛ**

Д.Бадамдорж

Түлхүүр үг: Хүн, хүлэг, сэтгэхүй, хэл, танин мэдэхүй, зэрэгцүүлэн сэтгэх, үндэстний сэтгэлгээ

Монгол хэлний судалгаа, сургалтыг монгол мэдлэгт түшиглэх нь бидний нэн тэргүүний зорилго билээ. Монгол мэдлэг гэж юу хэмээвээс монгол үндэстний хэдэн мянган жил оюун ухаанаа зарж бүтээсэн, танин мэдэхүйн буюу тархины үйлийн үр дүн, гаргалга юм. Монгол мэдлэг бол монгол хүний сэтгэхүй, хэл, танин мэдэхүйн цогц ойлголтын шинжтэй бөгөөд цогц ойлголтын хүрээ нь машид өргөн дэлгэр орон зайг эзэлдэг байна. Эрдэмтэн Ш.Гаадамба “Утга, чанар, шинж байдлаараа төстэй хоёр үзэгдлийг битүүгээр жишин адилтгаж, өгүүлбэрийн төстэй байгуулалтаар илэрхийлэн бичсэнийг *зэрэгцүүлэл* гэнэ” (1989:143) хэмээн тодорхойлсон ёсоор монгол цэцэн үг, зүйр үгийн дотор хүн ба хүлгийг зэрэгцүүлэн дүрсэлсэн танин мэдэхүй, үндэстний сэтгэлгээ, хэл хэлэхүйн холбоо хамаарлын илэрцийн хөдлөшгүй дархлаа тогтсон байгааг бид онцлон тайлбарлав. Монгол эсгий туургатан ажнай сайн хүлгийг “Заан нуруутай, Луугийн хүзүүтэй, Арслангийн нүдтэй, Гардийн жигүүртэй...” (Лувсанбалдан, 1989:190) хэмээн хүлэг морийг дөрвөн хүчтэнтэй зүйрлэн магтах бөгөөд төрийн сүлдний төв хэсэгт залсан нь гүн хүндэтгэлийн гэрч юм.

Монголчууд хүн хүлэг хоёрыг танин мэдэж, зэрэгцүүлэн сэтгэж, хүний үйлийг хэлэхийн сацуу морины шинж явдлыг хослуулан хэлэх ухаарлын **дархлаа** ч тогтсон байна. Хүн, хүлэг хоёрын тухай танин мэдэхүйн зэрэгцүүлэл монгол туургатны хэл, хэлэхүйд давтамжтай болсон байгааг нотлох баримтын талаар өгүүлье.

Монгол хэлний цэцэн, зүйр үгийн дотор хүн гэхээр хүлэг санаанд орсон зохиомж, ухаарал дэлгэр байна. Өөрөөр хэлбэл монгол хүн, хүлэг хоёрын тухай танин мэдэхүйн зэрэгцүүлсэн хэвшмэл хэллэгт хүүхэд ахуй цагаасаа түшигтэй эр хүн болох нь, унаган ахуй цагаасаа ажнай хүлэг болох нь илэрхий байдаг шинжийг аль эрт танин мэдсэн байна. Тухайлбал,

Хүн болох багаасаа (зэрэгцэхүүн)

Хүлэг болох унаганаасаа (хүнтэй зэрэгцүүлэхүүн)

хэмээн бага балчраас сайн үйлийг үйлдэн, аливаа үйлийг хичээн үйлдэхийг сургасан хэвшмэл хэлц үүсчээ. Мөн залуу зандан үедээ санаж сэрж явахыг анхааруулж, дахаар эр хүн, даахиар хүлэг морин хаалт хийж, даруухан нууцгайхан өсөж байдгийг ажиглан, танин мэдэж,

Дахан дор эр (зэрэгцэхүүн)

Даахин дор хүлэг (хүнтэй зэрэгцүүлэхүүн)

хэмээн сэцэлдэг ажээ. Мөн хүн, хүлэг хоёр ажил амьралын үйл явдалд орсоор байдаг учиртай билээ. Чингэвэл,

Ажил хийж **хүн** болдог (зэрэгцэхүүн)

Ар давж **хүлэг** болдог (хүнтэй зэрэгцүүлэхүүн)

хэмээн **хүн**, **хүлэг** хоёрын томоохон шалгуурыг танин мэдэж, ухаан суухын хэрд сурч судалж, ажил төрөл эрхэлж, эх орондоо ихийг бүтээж, сайн сайхан амьдрах талаар зөвлөсөн уламжлал бий. Монгол хүнийг насан туршдаа зөв хүнтэй нөхөрлөж, нийгмийн дунд нөхөрсөг харилцаатай байхыг сануулж,

Хүний сайныг ханилан байж мэднэ (зэрэгцэхүүн)

Хүлгийн сайныг унан байж мэднэ (хүнтэй зэрэгцүүлэхүүн)

хэмээн харилцаагаар нь танин мэдэх нэлээд нухацтай сургаалыг үеийн үед хайрлаж иржээ. Ийнхүү хүн хүлэг хоёрыг зэрэгцүүлэн өгүүлдгийн учир юу билээ гэвэл, хүнийг нөхөрлөсөн нөхрөөр нь шинж гэдэг сургаалын санаа бууж ирж байна. Монгол утга зохиолд **хүн**, **хүлэг** хоёрыг танин мэдсэн, зэрэгцүүлэн эргэцүүлэн бодохоор цэцэн үг, зүйр үг олон байдаг билээ.

Нэг. Эр хүн, хүлэг морь хоёрыг танин мэдсэн зэрэгцүүлэл

Эр хүн, хүлэг морь хоёрыг монголчууд эртнээс танин мэдэж, эр хүний тухай өгүүлэхэд л хүлэг морины тухай, хүлэг морины тухай ярихад л эр хүний тухай сэтгэн бодож, ямагт зэрэгцүүлэн дүрслэн хэлсэн байх юм.

Загвар нь:

ЭР ХҮН: САЙН ЭР САНАСАНДАА (эр хүн зорьсондоо хүрдгийг мэдсэн)

МОРЬ: САЙН МОРЬ ЗОРЬСОНДОО (хүлэг морин хүрэх, хүргэхийг мэдсэн)

Монголчууд эр хүн гэхээр морь гэж, морь гэхээр эр хүн гэж хосоор сэтгэн бодож, олон арван цэцэн зүйр үгийг бүтээсэн бөгөөд хүн адуу хоёрын тухай цогц ойлголтыг ч буй болгосон байна. Эр хүний мөс чанар хийгээд хүлэг морины олон шинжийг сайтар танин мэдсэний учир монгол үндэстний сэтгэлгээний зэрэгцүүлэл бүтээсэн байна. Энд хүн төвтэй танин мэдэхүйн утга зүйн үзэл баримтлалын үүднээс тайлбар өгвөл, **зэрэгцэхүүн** буюу монголчуудад хамгийн түрүүн өртөгдсөн **эр хүн**, **зэрэгцүүлэхүүн** буюу монгол эр хүнтэй эн түрүүнд холбон бодох **хүлэг морь** болно. Зэрэгцэхүүн, зэрэгцүүлэхүүн хоёрын тухай цогц санаа бол **зэрэгцүүлэл** юм. Бид хүнийг мал, амьтантай зэрэгцүүлэн сэтгэсэн гэж үзсэн юм. Өөрөр хэлбэл, зэрэгцэхүүн нь монгол эр хүн, зэрэгцүүлэхүүн нь хүлэг сайн морь тохиолдолд хүн, хүлэг хоёрыг сайтар танин мэдсэн **мэдлэг** илэрч байна. Бас эрдэмтэн Ж.Баянсан “Сэтгэлгээний тогтсон хэв шинж, тогтсон хэмжүүр нь тухайн соёл-хэлтэн юм үзэгдэл, үйл явдал, байдал нөхцөл, шинж чанарыг үнэлсэн үнэлэмж нь байдаг” (2002:31) хэмээн тодорхойлсон ёсоор монгол зарим зүйр цэцэн үгсээс ажиглахад хүн, хүлэг хоёрын шинжийг үнэлсэн үнэлэмж илэрхий харагдаж байна. Тухайлбал,

- Эр хүн, хүлэг морь хоёрын сайн шинжийг жишиж, дээдлэн эрхэмлэх утгатай зэрэгцүүлэл бол эр хүний ч, хүлгийн ч аль нэгэн өвөрмөц чанар шинжийг олон жилийн гяргай ажиглалтаар танин мэдэж, дүрслэн хэлсэн байх бөгөөд хойч үедээ эр хүн, хүлэг морь хоёрыг дээдлэх сургаалыг үлдээсэн байна. Жишээ нь:

Сайн **эрийн** санаа сайхан

Сайн **морины** зоо сайхан (ЗХТ)

Сайн **эр** гутахгүй

Сайн **морь** эцэхгүй (ЗХТ)

Өвгөн хүний үг хурц
Үрээ морины хөл хурдан (ГМД)

Аавын хүүгийн зориг хурц
Адуун сүргийн туурай хурц (ХХТ)

Сайн **морь** салхисаг
Сайн **хүн** найрсаг (ГМД)

гэх мэтээр эр хүн, хүлэг морь хоёрын шинжийг таньжээ.

- Эр хүн, хүлэг морь хоёрын муухан шинж, саарсан чадлыг жишин, шүүмжлэх утгатай зэрэгцүүлэл бол хэдий сайн авч саар шинж ч бас байгааг хэлжээ. Мөн цуцсан байдлыг ч өгүүлэв. Жишээ нь:

Даруулгагүй өссөн **хүүхэд**
Хазааргүй **морьтой** адил (ГМД)

Эцсэн **моринд** ташуур олон
Зүдэрсэн **эрд** ноён олон

Эцсэн **моринд** хазаар хүнд
Цуцсан **хүнд** гутал хүнд (МАЗҮ)

Доголон **мориноос** тоос их гарна
Дорд **хүнээс** их үг гарна (ГМД)

гэх мэтээр эр хүн, хүлэг морь хоёрын чадал шинж буурмал байдлыг ч дүрсэлж, сайны хажууд саар байдгийг сануулжээ.

- Эр хүн нийгэм олонтойгоо хамт, хүлэг морь ижилтэйгээ цуг орших байдлыг мөнхүү танин мэдүүлсэн утгатай цэцэн, зүйр үг хэрэглээнээс ажиглавал элбэг байна. Жишээ нь:

Сайн **эрд** нөхөр олон
Сайн **моринд** эзэн олон (МАЗҮ)

Агт **морь** адуундаа
Аав **хүн** хойморт (ХХТ)

Аавын буйд хүн тань
Агтны буйд газар үз (ГМД)

Эр сайт **нөхөр** даруухан
Эзэн сайт **морь** номхон (МАЗҮ)

гэх мэтээр эр хүн, хүлэг морь хоёр монголчуудын сэтгэлгээнд тод туссан байна.

- Эр хүн, хүлэг морь хоёроо хайрлах бахдах, эрч хүчийг нь үнэлэх цэгнэх сэтгэлгээ бүхий монгол зүйр цэцэн үгийн утга үе үеийнхэнд сургаал болсоор иржээ. Жишээ нь:

Уургач **морио** удаан битгий уна
Учирсан **нөхөртөө** уйдах үг битгий хэл (МАЗҮ)

Хүлэг морь эр хүний нөхөр
Хүдэр нум эрхий мэргэний нөхөр (ЗХТ)

Эр хүний дотор
Эмээл хазаартай **морь** (МАЗҮ)

Дахан дор **хүү** байдаг
Даахин дор **даага** байдаг (МАЗҮ)

Сайн **морь** чихэндээ
Сайн **эр** нүдэндээ (ГМД)

Эр хүн шиг эрвэлзэх
Эмээлт **морь** шиг дэрвэлзэх (ГМД)

гэх мэтээр эр хүн, хүлэг морь хоёрын тус тусын өвөрмөц шинжийг танин мэдээд хүн, хүлэг хоёрын загвараар танин мэдэхүйн утга зүйн зэрэгцүүлэл баяжсаар байна. Бид монгол хэлний цэцэн үг, зүйр үгийн утгыг танин мэдэхүйн утга зүйн чиг хандлагын үүднээс мөшгин үзвэл “Агтын сайныг уралдаанд, Эрийн сайныг бөхөд” (ХХТ) гэгчээр хүн, хүлэг хоёрын шинжийн цогц ойлголтод хүрч, судалгааны сонирхол улмаар өрнөв.

Хоёр. Эмэгтэй хүн, адуун сүрэг хоёрыг танин мэдсэн зэрэгцүүлэл

Эмэгтэй хүн, адуун сүрэг хоёрыг шүтэлцүүлэн сэтгэж, монгол үндэстний сэтгэлгээний зэрэгцүүлэл цөөнгүй бүтээн хэлсэн байна.

Загвар нь:

ЭМЭГТЭЙ ХҮН: БҮСГҮЙ ХҮНД АРХИ ЗОХИХГҮЙ (эмэгтэй хүнд архи шингэхгүй)

АДУУН СҮРЭГ: БУДУУН ГҮҮНД ЭМЭЭЛ ЗОХИХГҮЙ (тарган малд хэрэглэл таарцгүй)

Зэрэгцэхүүн нь эмэгтэй хүн, зэрэгцүүлэхүүн нь адуун сүрэг тохиолдолд монгол эмэгтэй хүн хийгээд адуун сүрэг хоёрын талаар монгол хүн олон зуун жил ажигласан учир мөн л монгол үндэстний сэтгэлгээ, танин мэдэхүйгээр олон цэцэн, зүйр үг бүтээсэн байна. Тухайлбал,

- Монгол эмэгтэй хүн, хүлэг морь хоёрын сайн шинжийн зэрэгцүүлэл нь эр хүн, хүлэг морь хоёрын зэрэгцүүлэлтэй төстэй байхын хамт эмэгтэй хүний сүүн цагаан сэтгэлийн жишиг шинж илүү илэрч байна. Жишээ нь:

Сайн **хүүхэн** харьд гарахгүй

Сайн **морь** нутаг алдахгүй (ЗХТ)

Эхнэр сайт замд өлсөхгүй

Морь сайт аянд алзахгүй (ЗХТ)

Хол замыг ойртуулах **морь** эрдэнэ

Хоёр айлыг ойртуулах **хүүхэн** эрдэнэ (МАЗҮ)

Сайн **морь** замын хань

Сайн **эхнэр** насны хань (ГМД)

Сайн **моринд** ганц эмээл

Сайн **хүүхэнд** нэг эр (ГМД)

Эр сайтай **эхнэр** даруухан

Эзэн сайтай **морь** номхон (ГМД)

гэх мэтээр монгол эмэгтэйн хүмүүнлэг шинжийг танин мэдэж, монгол морины ач тусыг магтан хослуулан сургасан байна.

- Монгол эмэгтэй хүн, адуун сүрэг хоёрын саар шинжийн зэрэгцүүлэл нь тэдгээрийн төстэй муухан шинжийг гярхай ажигласны эцэст эмэгтэй хүн, адуун сүрэг хоёрын ижлэвтэр байдал шинжийг шүүмжлэн хэлжээ. Жишээ нь:

Гүүний жороо

Чавганцын намжир хоёр адил (ЗХТ)

Нөхөргүй **эм**

Азаргагүй **гүү** хоёр адил (ЗХТ)

Сургаалгүй **эм**

Хазааргүй **гүү** хоёр адил (ЗХТ)

Аальгүй хүүхэн аяга шаазан дээгүүр

Агсам морь айл хунар дээгүүр (ХХТ)

гэх мэтээр харьцуулан, зэрэгцэхүүн зэрэгцүүлэхүүн хоёрын утга нь:

Аальгүй хүүхэн үгэнд унана

Агсам морь нүхэнд унана (ХХТ)

гэгчийн үлгэрээр тайлбарлаж болох байна.

Гурав. Монгол хүн, адуун сүрэг хоёрын хүйс ялгаагүй танин мэдсэн зэрэгцүүлэл

Монгол хүн, адуун сүрэг хоёрын хүйс ялгаагүй, олон шинжийн зэрэгцүүлэл бол зэрэгцэхүүн нь монгол хүмүүн, зэрэгцүүлэхүүн нь адуун сүрэг тохиолдолд дараах танин мэдэхүй, сэтгэлгээ, хэлний холбоо хамаарал мэдэгдэж байна.

Загвар нь:

МОНГОЛ ХҮН: УХААНТАЙ ХҮНИЙ ҮР (удам угсаа сайтай)

УДАМТ ХҮНИЙ ҮР /хувилбар/

АДУУН СҮРЭГ: СҮҮТЭЙ ГҮҮНИЙ УНАГА (угшил сайтай)

УГШИЛТ ГҮҮНИЙ УНАГА /хувилбар/

Эрдэмтэн Ц.Шагдарсүрэн “Энэ нь хүнийг шинжих гол хэмжүүр болж байсан бөгөөд энэ үгнээс монголчуудын гарвализүйн мэдэлгэ харагдана” (2003:173) хэмээн хэлжээ.

Монгол хүн, адуун сүрэг хоёрын тухай монгол мэдлэгийн илэрц нь монгол хүн, адуун сүрэг хоёрыг хосоор зэрэгцүүлэн сэтгэн бодох үед л тодорхой болж ирж байна. Тухайлбал,

- Монголчуудын малаа өсгөж хайрлах сайхан сэтгэл, зүс нь нэг адуун сүргийн ач тус зэргийг харьцуулан, юуны өмнө монгол хүний хүнлэг даруу зан ааль, адуун сүргийн ааш араншинг танин мэдсэн зүйр цэцэн үг үлэмж байна. Жишээ нь:

Эетэй хүнд нөхөр олон

Эрэмгийн моринд эзэн олон (ЗХТ)

Сайн хүн нэг үгтэй

Сайн морь нэг явдалтай (МАЗУ)

Сайн хүн зөвшөөч

Сайн морь хатираач (ГМД)

Айл хүний амь нь нэг

Адуу малын бэлчээр нь нэг (ХХТ)

гэх мэтээр ихэвчлэн хүн, морь хоёрын зэрэгцүүлэл байх бөгөөд аль алиныг нь сайтар танин мэдэж, эерэг сэтгэлгээний дангааршсан дархлаа тогтжээ.

- Монголчууд хүн, морь хоёрыг зэрэгцүүлэн сэтгэж цэцлэхдээ ёс зүйн уламжлал буй болгосон байна. Жишээ нь:

Хүн муу боловч ёстой нь дээр

Хүлэг муу боловч хазаартай нь дээр (ЗХТ)

Гүйцээж унших нь хүний ёс

Гүйцэж түрүүлэх нь хүлгийн ёс (ЗХТ)

Айл бассан хүн нөмгөнөөр орно

Адуу бассан хүн амгайвчилж унана (МАЗУ)

Монгол **хүн** ёсоо дээдэлдэг

Морьтон ард **хүлгээ** биширдэг (ГМД)

гэх мэтээр хүн, хүлэг хоёрт таацах ёсыг ч танин мэдсэн байна.

- Монгол хүн, адуун сүрэг хоёрын тухай зэрэгцүүлэлд хүн ба адууны муухан шинжийг хослуулан хэлсэн байна. Жишээ нь:

Хүнд хэлүүлсэн

Хүлэгт булгиулсан хоёр адил (ЗХТ)

Муу **хүний** маяг их

Муу **морины** цанх их (ЗХТ)

Худалч **хүн** хожимдоо муу

Хусран **гүү** хавартаа муу (ЗХТ)

Гэмт **хүн** гилбэлзэнэ

Даарьт **морь** далбалзана (МАЗҮ)

Алиа **хүн** авиргүй

Агсам **морь** жороогүй (МАЗҮ)

Агсам **морь** эмээлдээ халтай

Ардаг **хүн** биедээ халтай (ХХТ)

гэх мэтээр хүний тааруу шинжийг адууны муу шинжтэй нэг ёсоор зүйрлэж, аль алины байдал шинжийг танин мэдсэний л үр дүн юм.

- Эрдэнэт хүн хийгээд адуун сүргийн хэм хэмжээг тогтоодог аргыг танин мэдэж, сургасан утгатай цэцэн зүйр үг хэрэглээнээс ажвал, цөөнгүй бий. Жишээ нь:

Зангаараа явбал **биед** амар

Замаараа явбал **моринд** амар (ЗХТ)

Хүн хувцсаар

Морь таргаар (ЗХТ)

Хүнийг аргаар

Хүлгийг уургаар

Ууртай **хүнийг** аргаар

Ороо **морийг** уургаар

Хүн хоолоор

Хүлэг өвсөөр (ЗХТ)

Зөв үгэнд **хүн** бөхийнө

Зүлгэн газарт **морь** хөрвөөнө (МАЗҮ)

гэх мэтээр хүн, адуу хоёрын төстэй шинжийг танин мэдсэн байна.

- Хүн хүлэг хоёрын өвөрмөц чанар шинжийг танин мэдсэн утгатай зүйр цэцэн үг монгол үндэстний сэтгэлгээгээр буй болжээ. Жишээ нь:

Хүний шарх дотроо

Хүлгийн шарх гаднаа (ЗХТ)

Сайн **хүн** нэг үгэнд

Сайн **морь** нэг ташуурт (ГМД)

Азарга байдсаа ялгадаг

Хүн төрлөө ялгадаг (ХХТ)

Хүний тамир зүрхэндээ

Хүлгийн тамир туурайндаа (ГМД)

гэх зэргээр хүн, хүлэг хоёрт буй тус тусын шинжийг зэрэгцүүлэн таньсан байгаа нь хэрэглээнээс илхэн байна.

- Хүн, хүлэг хоёртой холбоо бүхий танин мэдсэн мэдлэгийг үндэслэж, товч сануулга хэлсэн байна. Жишээ нь:

Ил газар **морио** уя

Итгэсэн **хүнд** үгээ хэл (МАЗҮ)

Агсам **моринд** уурга бүү алд

Аливаа **хүнд** үг бүү алд (ГМД)

Жолоогүй **морь**

Зорилгогүй **хүн** (ГМД)

гэх мэтээр хүн хүлэг хоёрын занг нэвтэрхий танин мэдсэн сургаал юм. Эрдэмтэн С.Дулам, Г.Нандинбилэг нар “Зүйр цэцэн үг бол бараг бүхэлдээ ардын сурган хүмүүжүүлэх зүйн аман онол, үйлдлэг, бичмэл бус хөтөлбөр, сурах бичиг мөн.” (2007:144) хэмээн цэгнэн хэлсэн дүгнэлт **хүн хүлэг** хоёрын танин мэдэхүйн утга зүйн зэрэгцүүлэл судлах явцад улмаар нотлогдож байна.

Дөрөв. Хүн, мал хоёрыг танин мэдсэн зэрэгцүүлэл

Хүн, мал хоёрын танин мэдэхүйн зэрэгцүүлэл нь зэрэгцэхүүн нь монгол хүн, зэрэгцүүлэхүүн нь таван хошуу мал тохиолдолд дараах танин мэдэхүйн утга зүйн цогц ойлголт илэрч байна. Тухайлбал, хүн ба малын аль алины нь ноцтой шинжийг танин мэдсэн зэрэгцүүлэл бүхий монгол цэцэн зүйр үг арвин байдаг.

Загвар нь:

ХҮН: ТАРГАН ХҮН ТАЛ БҮРИЙН ӨВЧИНТЭЙ (*Хүний тарга өвчний нөлөөтэй*)

МАЛ: ТАРГАН МАЛ ТАЛ БҮРИЙН АШИГТАЙ (*Малын тарга өвчний нөлөөгүй*)

хэмээх зэрэгцүүлэл бол хүн ба малын зарим шинжийг танин мэдээд, ухан жишиж, эерэг сөрөг утгатай болохыг харшуулан хэлсэн байна. Эрдэмтэн Н.Нансалмаа нар “...Танихуйн утга зүй нь уламжлалт утга зүйн хүрээний асуудалд **хэрэглээгүйг** нэгтгэсэн хэрэг юм” (2014:117) гэж тодорхойлсон ёсоор монгол зүйр цэцэн үгийг олшруулан жишээлсэн юм.

Хүний бие, хэл, сэтгэлийн шинж чанар, үйл хөдлөл, орчны харьцааг таван хошуу малын шинж байдал, ааш араншин, үйл хөдлөл зэрэгтэй орон зай, цаг хугацааны орчилд зэрэгцүүлсэн зүйр цэцэн үгийг монголчууд бүтээж, хойч үеийнхэн нь уламжлан авч, дамжуулсаар байна. Жишээ нь:

Хүн хэлээрээ

Мал хөлөөрөө (ЗХТ)

Хүн хөдөлмөрөөр

Мал бэлчээрээр (ЗХТ) гэх мэт.

- Монгол хүн малын харилцааны байдлыг танин мэдэж, ёс, бэлгэдэл тогтож, монгол сэтгэлгээний нэгэн өвөрмөц дархлаа болсон байна. Жишээ нь:

Алах **хүний** өчгийг ав

Алах **малын** хишгийг ав

Алах **хүний** өчгийг ав
Алах **үхрийн** дөрийг ав (ХХТ)

Өөдлөх **айлын** үг нь нэг
Өсөх **малын** зүс нь нэг (МАЗУ)

Гунан нас хүрээгүй **хониор** тэнгэр тахидаггүй
Гучин нас хүрээгүй **хүнээр** төр бариулдаггүй (ГМД)

Идээгээр дайлах нь **хүний** ёс
Ижилсэн дасах нь **малын** ёс (ЗХТ) гэх мэт.

- Хүн хийгээд малын сайн шинж чанарыг ялган танин мэдэж, залгамж үедээ сургаал болгосон нь хэрэглээнээс тодорхой байна. Жишээ нь:

Биеэ мэдвэл **хүн**
Бэлчээрээ мэдвэл **мал** (МАЗУ)

Жаварт төрсөн **малын** үр
Жаргалд төрсөн **хүний** үр (ГМД)

Ирэг тарган бол хот дүүрэн
Иргэн баян бол улс баян (ГМД)

Мал тэжээвэл ам тосодно
Хүн тэжээвэл хүч нэмнэ (ГМД) гэх мэт.

- Хүн хийгээд малын муу муухан шинжийг танин мэдээд, тааруу хоёр шинжийг зэрэгцүүлэн сэтгэж, сургаалтай зүйр цэцэн үгийг бүтээжээ. Жишээ нь:

Өсөхөө больсон **мал** хот дотроо мөргөлдөх
Өөдлөхөө больсон **айл** гэр дотроо хэрэлдэх (ГМД)

Хүн гэмээ мэдэхгүй
Тэмээ гэдгэрээ мэдэхгүй (МАЗУ)

Буруу өссөн **хүүхэд**
Бухын хүзүүнээс хатуу (ГМД)

Өвстэй газар **мал** тогтдоггүй
Жаргалтай газар **хүн** тогтдоггүй (ГМД)

Лам муудвал дуулах
Ямаа муудвал майлах (ГМД)

Үйлгүй **хүүхэн** дууламхай
Сүүгүй **үнээ** мөөрөмхий (ДБ)

Олон **хүүхэнтэй** газар хов тасардаггүй
Олон **ямаатай** хонь бэлчээрт тогтдоггүй (ГМД)

Сүмгүй **лам**
Сүрэггүй **бух** (ГМД)

Угаа мэдэхгүй **хүн**
Усаа мэдэхгүй **мал** (ГМД)

гэх мэтээр “мал айл, хүн тэмээ, хүүхэд бух, мал хүн, лам ямаа, хүүхэн үнээ, хүүхэн ямаа, лам бух, хүн мал” зэргийг чанар шинжээр нь зэрэгцүүлэн дүрсэлсэн байна. Энд зэрэгцэхүүн, зэрэгцүүлэхүүн хоёр нь хоёул дутагдалтай байгааг харгалзсан ухаарал юм. Ийм зэрэгцүүлэх сэтгэлгээ нэлээд түгээмэл байна.

- Хүн, мал хоёрын ааш занг зэрэгцүүлэн, танин мэдсэн мэдлэгийн ёсоор сургасан зүйр цэцэн үг бий. Жишээ нь:

Уйлан уйлан **хүн** болдог

Майлан майлан **мал** болдог (МАЗҮ)

Өвс задлахад **үхэр** баярлах

Үүц задлахад **хүүхэд** баярлах (ГМД)

Олиггүй **эр** эхнэртээ дээрэлхүү

Оготор **бух** бяруундаа дээрэлхүү (ГМД)

Хүн ижилдэх тусмаа уйддаг

Мал удах тусмаа ижилддэг (ГМД) гэх мэт.

Тав. Хүн, амьтан хоёрыг танин мэдсэн зэрэгцүүлэл

Танин мэдэхүйн утга зүйн зэрэгцүүллийн зэрэгцэхүүн нь **хүн**, зэрэгцүүлэхүүн нь малаас бусад **амьтан** тохиолдолд үндэстний доорх сэтгэлгээ илэрч байна.

Загвар нь:

ХҮН: НОЁН УРВААЧ (ноён хүний туйлбаргүй зан чанарыг илтгэсэн)

АМЬТАН: НОХОЙ ШАРВААЧ (нохойн адармаатай аранишнг жишиж илтгэсэн)

- Хүн ба амьтан гэх танин мэдэхүйн зэрэгцүүлэл нь хүний үйл, амьтны явдлыг танин мэдсэн нь илхэн байна. Жишээ нь:

Хүний зөөлнийг **хүн** олох

Модны зөөлнийг **тоншуул** олох (ДБ)

Бөө бөөгийн бөөлөх нь ондоо

Бөжин туулайн шогших нь ондоо (МАЗҮ)

Могойн эрэн гаднаа /байдаг/

Хүний эрэн дотроо /байдаг/ (ГМД)

гэх мэт. Монгол хүн зэрэгцэхүүн ба зэрэгцүүлэхүүнийг яаж бодож олдог нь сонин юм. Бидний судалж буй **хүн - хүлэг** хоёр, **хүн - мал** хоёр, **хүн - амьтан** хоёрын ямар ямар шинж байдлыг зэрэгцүүлж болох вэ? хэмээн сэтгэн эргэцүүлдэг байна. Юуны өмнө яруу найргийн толгой холбох ёсыг бодож, энэ шинж хүнд байхад, мөн тийм шинжээр ямар амьтанд байж болохыг л сэтгэн бодож олдог замтай байна. Чингэвэл,

Зэм ахад

Зуд тэхэд (ДБ)

гэхэд буруушаан зэмлэхэд ахмадад нь зэм ирдэг бол цагаан ба харын зуд болоход эцэг амьтан тэхэд зовлон оногдох учир зүй байх нь. Энэ бол монгол сэтгэхүй, танин мэдэхүй, хэл гурвын нарийн холбоо юм.

- Хүнийг ажил үйл, шинж байдал, зан чанар, үйл хөдлөлөөр нь амьтантай зэрэгцүүлсэн цэцэн үг, зүйр бол тооны хувьд цөөн боловч, хүн ба амьтны талаархи мэдлэг гүнзгий байгааг харуулж байна. “Тархинд буй хэл олон цогц ойлголтын нэгдэл” (Нансалмаа, Н., Долгор С. 2014:119) хэмээн ойлгож, хүн төвтэй хүн ба амьтан гэсэн зэрэгцүүлэл бол орон зайн дараах хүрээтэй болно. Тухайлбал, жинхэнэ хэрэглээг ажиглая.

Хүн загас хоёр:

Зан сайтай айлд **хүн** цуглардаг

Замаг сайтай нууранд **загас** цуглардаг (ГМД)

Хүн шувуу хоёр:

Сайн **хүн** нэрээ хайрлана

Тогос **шувуу** сүүлээ хайрлана (ГМД)

Хүн нохой хоёр:

Хүн ёс дагана

Нохой яс дагана (ГМД)

Хүн үнэг хоёр:

Хүн үгэндээ үхнэ

Үнэг үсэндээ үхнэ (ДБ)

Хүн могой хоёр:

Муу **хүн** нүгэлдээ харлана

Могой хорондоо шарлана (ГМД)

Хүн чоно хоёр:

Хүний хүү гэр тийшээ

Чонын хүү ой тийшээ (ГМД)

Жанжин заан хоёр:

Жанжин хичнээн их ч олны аясыг дагана

Заан хичнээн том ч замын аясыг дагана. (ДБ)

гэх мэт. Эл зэрэгцүүллийн зэрэгцэхүүн зэрэгцүүлэхүүн хоёр нь хэлбэр утгын хэм хэмжээ ихэд төстэй байдаг онцлогтой юм. Монгол хүн гүнзгий бодож боловсруулж, бодит байдлаас урган гарсан үнэнийг хэлдэг байна.

Бид монгол хэлний хүн төвтэй зэрэгцүүллийг энэ удаад “хүн, хүлэг хоёр” хэмээсэн агуулгаар танин мэдэхүйн утга зүйн цогц ойлголтыг тайлбарлаж, монгол хүний хүн ба юмыг танин мэдсэн орон зай, цаг хугацааны цар хүрээг мөшгөлөө.

Abstract

The author deals with the Man and horse issues depicted in Mongolian proverbs and quotas. For instance, Mongolian nurtured children (1) in minor ages like saying “The child is the father of the man. (2) in young ages “Labor made man” and (3) “Familiarity breeds contempt” in all ages. The **Proverbs** of the Mongolian languages:

1. **Kumun bolqu бага-aca**

Kulug bolqu unagan-aca.

2. **Ajil kiju kumun boldag**

Aru dabaju kulug boldag.

3. **Kumun-u sayin-i qanilan bayiju medemui**

Kulug-un sayin-i unun bayiju medemui.

Номзүй

Баясан Ж. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ. Уб., 2002.

Гаадамба Ш. Утга зохиолын онолын үндэс. Уб., 1989.

Гаадамба Ш., Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Уб., 1978.

Дулам С., Нандинбилэг Г. Монгол аман зохиолын онол. Уб., 2007.

Лувсанбалдан Х. Хулгийн шинж. Уб., 1989.

Нансалмаа Н., Долгор С. Танихуй хэл шинжлэл. Уб., 2014.

Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. Уб., 2003.

ГМД - Монгол зүйр цэцэн үгийн гурван мянган дээж. Эмх. Д.Заяабаатар. Уб., 1999.

ЗХТ - Зүйр цэцэн үгийн зүйлээр хуваасан толь. Эмх. найруулсан Ж.Бат-Ирээдүй. Уб. 2005.

МАЗУ - Монгол ардын зүйр үг. Эмх. Н.Дамбасүрэн. Уб., 1959.

ХХТ - Монгол хэлний хэвшмэл хэлцийн толь. Эмх. С.Чулуунпүрэв, Б.Одончимэг. Уб., 2012.